

БАТЛАВ: /Г.ЦЭНДСҮРЭН/  
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ТӨВИЙН  
УСАН САНГИЙН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024.12.02

1	Ажил гүйцэтгэх үндэслэл:	<ul style="list-style-type: none"><li>Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төвд одоо 400 тн усан сангийн байгууламж байдаг ч төвийн хүн амын нягтшилаас хамаарч ундны цэвэр усны хэрэглээ нэмэгдэн хуучин усан сангийн байгууламжийн хүчин чадал хүрэлцэхгүй болж нэмэгдүүлэх шаардлагатай болсон,</li><li>Сумын нийт иргэдийн 2023, 2024 оны ОНХС-ийн санал асуулгын дүн,</li><li>Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэр, фермерийн үйл ажиллагаа явуулах хэрэгцээ,</li><li>Сүүлийн жилүүдэд суманд шилжин ирэгчид нэмэгдэх хандлагатай байна. Байнга оршин суугчид 5100 хүнтэй бөгөөд жилд дунджаар 100-120 хүнээр нэмэгдэж, түр болон дайран өнгөрөх, мөн хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалтын түр ажилд хөдөлмөр эрхлэх хүний тоо дунджаар 150-200-аар нэмэгдэж байна.</li></ul>
2	Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	<ul style="list-style-type: none"><li>Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга нэмэлтээр хийх).</li><li>Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төвийн усан сангийн байгууламжийн (1000 тонноос багагүй) ажлын иж бүрэн зураг төсөл, төсөв боловсруулан хүлээлгэж өгөх.</li><li>Гэрээнд заасан хугацаагаар.</li></ul>
3	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал:	<ul style="list-style-type: none"><li>Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төвд одоо 400 тн усан сангийн байгууламжтай.</li><li>Одоо байгаа гүний худаг өдөрт 150 м/куб хүчин чадалтай байна.</li></ul>
4	Ус зүй, инженер геологийн судалгаа:	<ul style="list-style-type: none"><li>Газар дээр нь ирж үзэж танилцах,</li><li>Инженер геологийн судалгаа,</li><li>Одоо байгаа ундны усны эх үүсвэрийг шинжилгээнд өгөх,</li></ul>

5	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал:	<p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• БД 81-106-11 Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм</li> <li>• БНБД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь</li> <li>• БНБД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл</li> <li>• БНБД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц</li> <li>• БНБД 33-08-09 Бетон ба төмөр бетон боомт</li> <li>• Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гидрогеологийн сэдэвчилсэн, дунд том масштабын зураглал, ашигт малтмалын хайгуулын ажлын явцад ордын гидрогеологийн судалгаа хийх заавар, тавих шаардлага.</li> <li>• Бусад норм, норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар</li> </ul>
6	Ажлын зураг төслийн бүрдэл:	<p>Усан сангийн байгууламжийн ажил:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Талбайд баршил, орчны судалгаа, инженер геологи, гидрологи ус зүйн судалгаа тооцоо хийх</li> </ul> <p>Баримт бичгийн бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тайлбар бичиг</li> <li>• Инженер геологийн дүгнэлт</li> <li>• Ус зүйн судалгааны тооцоо</li> <li>• Ажлын тоо хэмжээ</li> <li>• Материалын түүвэр</li> <li>• Усан сангийн байгууламжийн төсөв</li> <li>• Дэвсгэр зураг (топо)</li> <li>• Магадлалын нэгдсэн дүгнэлт</li> </ul> <p>Зураг төсөлд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зураг төслийн баримт бичиг 4 хувь байна. Инженер геологийн дүгнэлт тайланг 2ш хувь хүлээлгэж өгөх</li> </ul>
7	Зөвшилцөх байгууллагууд	<p>Усан сангийн байгууламжийн зураг төсөлд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Болзошгүй газар хөдлөлийн аюулыг тодорхойлж зураг төсөл боловсруулах</li> <li>• Төсвийг ESTIMATOR-PRO программ болон түүнтэй төстэй зөвшөөрөгдсөн программаар тооцно.</li> <li>• Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх.</li> </ul> <p>Баталгаажуулалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төв, Ус сувгийн удирдах газар болон мэргэжлийн байгууллагаар магадлал хийлгэх;</li> </ul> <p>Зөвшилцөх байгууллагууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сумын ЗДТГ, Тохижилт, Газрын даамал</li> <li>• Аймгийн ГХБХБГазар, ОБГ, Эрүүл мэндийн газар, аймгийн ерөнхий архитектор.</li> </ul>
8	Архитектурын төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Сумын төвийн суурьшлын байдал, айл өрх, байгууллага ААН, инженерийн шугам сүлжээ болон дэд бүтцийн байгууламжууд болон ирээдүйн суурьшлын зураглалтай уялдуулж төлөвлөх</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Орчин үеийн дэвшилтэт технологи тоноглолоор тоноглох</li> <li>• Шинээр хийх усан сангийн байршлыг судалгаа тооцооны үндсэн дээр сонгох</li> <li>• Одоо байгаа усан сангаас зайтай баригдахаар бол хооронд нь хэрхэн холбох шийдлийг гаргаж өгөх</li> </ul>
9	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг Estimator-Pro программ болон түүнтэй ижил тооцдог зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно
10	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээнд заасан хугацаагаар
11	Зураг төсөл боловсруулах байгууллага	Эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл. /ЗТ-3.1, ЗТ-3.2, ЗТ-3.4/
12	Зураг төслийн санхүүжилт	Аймаг, сумын хөрөнгө оруулалт
13	Төслийн зохицуулагч	-Б.Ууганбаяр /Засаг даргын орлогч/
14	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын төвийн Тийрэг 3 дугаар багийн хойд хэсэгт байрлах хуучин усан сангийн байгууламжтай холбох боломжийг судлан тохирч хийх,</li> <li>• Эсвэл боломжит шинэ байршил сонгож иж бүрнээр хийх зэрэг боломжуудыг судлан зөвшилцөж, 1000тн-оос багагүй багтаамжтай усан сангийн байгууламж төлөвлөх.</li> </ul>

**Боловсруулсан:**

Цагааннуур сумын Засаг даргын орлогч: ..... /Б.Ууганбаяр/

**Хянасан:**

Цагааннуур сумын Засаг даргын тамгын газрын дарга ...../Д.Алтанзориг/